

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД, САНГИЙН САЙДЫН ХАМТАРСАН ТУШААЛ

2021 оны 06 дугаар
сарын 21-ны өдөр

Дугаар 4/337 .99

Улаанбаатар хот

Журамд нэмэлт оруулах, төлбөрийн хэмжээг шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Коронавируст халдвар (КОВИД-19)-ын эсрэг эрүүл мэндийн цогц тусламж, үйлчилгээг санхүүжүүлэх журам, тусламж, үйлчилгээний багц, төлбөрийн хэмжээ батлах тухай” Эрүүл мэндийн сайд, Сангийн сайдын 2021 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн 67/A/268 дугаар хамтарсан тушаалын нэгдүгээр хавсралтаар баталсан “Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын дэгдэлтийн үед үзүүлэх цогц тусламж, үйлчилгээг санхүүжүүлэх журам”-д дор дурдсан агуулга бүхий хэсэг, заалт нэмсүгэй:

1. Хоёр дугаар зүйлийн 2.2.5 дахь заалт:

“2.2.5. сорьцод ПГУ Cov-SARS 2 шинжилгээ хийх”

2. Хоёр дугаар зүйлийн 2.7 дахь хэсэг:

“2.7. “сорьцод ПГУ Cov-SARS 2 шинжилгээ хийх” гэдэгт энэ журмын 2.3-т заасан сорьцыг лабораторид шинжилж, үр дүнг тодорхойлоход гаргах зардлыг хамруулна”

3. Гурав дугаар зүйлийн 3.3¹ дахь хэсэг:


“3.3¹. Эмнэлзүйн удирдамжийн дагуу явуулын багийн коронавируст халдвар (КОВИД-19)-ын сэжигтэй тохиолдлоос авсан нэг сорьцод ПГУ Cov-SARS 2 шинжилгээ хийж үр дүнг тодорхойлсныг нэг тохиолдол гэж үзэж тусламж, үйлчилгээний төлбөрийн жагсаалтын 5 дугаар багцын дагуу харгалзах тарифаар тооцон шинжилгээ хийсэн байгууллагад санхүүжилт олгоно.”

2. “Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын дэгдэлтийн үед үзүүлэх цогц тусламж, үйлчилгээний багц, төлбөрийн хэмжээ”-г хавсралт ёсоор шинэчлэн баталсугай.

3. Хавсралтаар батлагдсан “Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын дэгдэлтийн үед үзүүлэх цогц тусламж, үйлчилгээний багц, төлбөрийн хэмжээ”-г 2021 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс тооцон хянаж, санхүүжүүлэхийг Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын дарга /Л.Бямбасүрэн/-д даалгасугай.

4. Энэ тушаал батлагдсантай холбогдуулан “Коронавируст халдвар (КОВИД-19)-ын эсрэг эрүүл мэндийн цогц тусламж, үйлчилгээг санхүүжүүлэх журам, тусламж, үйлчилгээний багц, төлбөрийн хэмжээ батлах тухай” Эрүүл мэндийн сайд, Сангийн сайдын 2021 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн 67/A268 дугаар хамтарсан тушаалын хоёрдугаар хавсралтыг хүчингүй болгосугай.

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД



С.ЭНХБОЛД

САНГИЙН САЙД



Б.ЖАВХЛАН

Эрүүл мэндийн сайд, Сангийн сайдын 2021 оны

МЗСЭГ/99 дугаар хамтарсан тушаалын хавсралт

Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын дэгдэлтийн үед үзүүлэх цогц тусламж, үйлчилгээний багц, төлбөрийн хэмжээ

Багцын дугаар	Тусламж, үйлчилгээний багцын нэр	Үйл ажиллагаа	Тусламж, үйлчилгээг үзүүлэх этгээд	Төлбөрийн хэмжээ (төгрөг)
1	Тандалтын ПГУ шинжилгээ	Явуулын баг ажиллуулж сорьц цуглуулах	Шинжилгээний явуулын баг	5,000
2	Гэрээр үзүүлэх тусламж, үйлчилгээ;	Шинжилгээгээр баталгаажсан, шинж тэмдэггүй, хөнгөн хэлбэрийн өвчтөнийг гэрээр эмчлэх, зөвлөгөө өгөх 3.1. Халдвар авсан нь шинжилгээгээр баталгаажсан боловч гэрт нь тусгаарлах боломжгүй, шинж тэмдэггүй, хөнгөн хэлбэрийн өвчтөнийг тусгаарлан эмчлэх	Анхан шатлалын эрүүл мэндийн байгууллага	160,000
3	Хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээ	3.2. Эрсдэлтэй хөнгөн, хүндэвтэр өвчтөнийг эмнэлэгт хэвтүүлэн эмчлэх 3.3. Хүнд өвчтөнийг эмнэлэгт хэвтүүлэн эмчлэх 3.4. Маш хүнд өвчтөнийг эмнэлэгт хэвтүүлэн эмчлэх	Зориулалтын ор бүхий түр эмнэлэг, тусгаарлан эмчлэх байр Сум, тосгоны эрүүл мэндийн төв Хөнгөн Хүндэвтэр Хүнд Маш хүнд	980,000 980,000 2,160,000 4,200,000 7,465,000
4	Коронавируст халдвар /КОВИД-19/ өвчний эсрэг дархлаажуулалт	Дархлаажуулалт хийх бүлгийн насанд хүрсэн хүн болон хүүхэд	Бүх шатлалын эрүүл мэндийн байгууллага, тусгайлан бэлтгэсэн дархлаажуулалт хийх төв	5,000
5	Сорьцод ПГУ Cov-SARS 2 шинжилгээ хийх	Тандалтын зорилгоор хийгдэж буй сорьцод шинжилгээ хийх	Төрийн эрүүл мэндийн байгууллага	50,000